# ГАРЧИГ


1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ....................................................................3

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ....................................................................11

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ ....................................................................14

4. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ....................................................................18

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 20

5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ....................................................................24

6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ....................................................................25

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ....................................................................25

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ...............25

БҮЛЭГ 9.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.......................................26

БҮЛЭГ 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..........................................27

БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ................................................28

БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .......................30

БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ....................................................................31

**Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилцолууд....3
Хүснэгт 2. Ил уурхайн ажлын горим....6
Хүснэгт 3 Уурхай ашиглалтын систем....7
Хүснэгт 4 Бутлан ангилах цехийн цагийн хүчин чадал....8
Хүснэгт 5. Тоног төхөөрөмжийн нэгдсэн хүснэгт....9
Хүснэгт 6 Барилга, байгууламж, хийц бүтэц....9
Хүснэгт 7. Болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим....16
Хүснэгт 8. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа....19
Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө....20
Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ....25
Хүснэгт 11. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө....26
Хүснэгт 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө....27
Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр....28
Хүснэгт 14. БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө....30
Хүснэгт 15. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах төлөвлөгөө....31

**Зургийн жагсаалт**

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг....4
Зураг 2. Талбайн баруун хэсгээс УБ хот харагдаж буй нь....4
Зураг 3. Цагаандаваа барилгын чулууны ордын ерөнхий байдал....4
/Баруун урдаас зүүн хойд хэсэгт харагдах байдал/....4
Зураг 4. Ордын нөөцийн дэвсгэр зураг....5
Зураг 5. Ил уурхайн загварчлал....6
Зураг 6. Ил уурхайн ашиглалтын 5 дах жилийн зураг....7
Зураг 7. Бутлан ангилах цехийн технологийн схем....8
Зураг 8. Бутлах ангилах хэсгийн тоног төхөөрөмж....9
Зураг 9. Бутлах ангилах цехийн тоног төхөөрөмжийн холболтын схем....10
Зураг 10. ТМ-250/10/0.4 маркийн трансформатор....10
Зураг 11. Хөрсөн бүрхэвч....11
Зураг 12. Ургамалжилтын ангилалын зураг....12

# ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр:** Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутагт орших “Цахир жалга” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл

**Төсөл хэрэгжүүлэгч:** “Эрдэнэ цагаач” ХХК /улсын бүртгэлийн дугаар: 9011560067, регистрийн дугаар: 5979374, албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 18-р хороо, 13 хороолол 37/53 тоот, утас: 96668341

**Төслийн байршил:** Цахир жалгын хөв алтны шороон орд нь Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутагт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос баруун зүгт 700 орчим км-т, Баянхонгор аймгийн төвөөс баруун тийш 100 км-т, Бөмбөгөр сумын төвөөс зүүн тийш 22 км зайд оршино.

***Хүснэгт № 1 Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилцлууд***

| № | Өргөрөг | Уртраг |
|---|---|---|
| 1 | 46°18'40"N | 99°48'38"E |
| 2 | 46°20'0"N | 99°48'38"E |
| 3 | 46°20'0"N | 99°47'20"E |
| 4 | 46°18'40"N | 99°47'20"E |



***Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг***



***Зураг 2. Талбайн баруун хэсгээс***



***Зураг 3. Төслийн талбайн харагдах байдал***

**Төслийн нөөц ба хүчин чадал**

**Нөөц:** Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутаг дахь MV-020998 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах “Цахир жалга” нэртэй алтны шороон орд ашиглалтын нийт хугацаанд 198.8 мян.м3 хөрс хуулж, 58.12 мян.м3 элс олборлон баяжуулахаар байгаа бөгөөд хөрс хуулалтын дундаж коэффициент 3.42 м3/м3 байна. Ашиглалтын хугацаанд уурхайгаас дунджаар 807 мг/м3 агуулгатай, технологийн хаягдал тооцоод химийн цэврээр 22.73 кг алт олборлон борлуулахаар тооцсон байна. Ордын жилд 29.06 мян.м3 элс олборлон боловсруулж химийн цэврээр 10.06-12.66 кг алт үйлдвэрлэх хүчин чадлаар ажиллах бөгөөд батлагдсан геологийн нөөцийг нийт 2 жилд ашиглахаар байна. Үйл ажиллагаа явуулах эхний 2 жилийн хугацаанд 58.12 мян.м3 элс олборлон химийн цэврээр 22.73 кг алт үйлдвэрлэнэ.

"Цахир жалга" алтны шороон ордын алттай давхаргад геологийн нөөцийн 12, үүнээс бодитой (B) зэргээр 9, боломжтой (C) зэргээр 3 блок тус тус ялган нөөцийн тооцоог үйлдсэн байна.

Хайгуулын ажлын явцад нийт 13 хайгуулын шугаманд 60 шурф малтаж, эдийн засгийн хувьд ашигтай байх бодитой (B) нөөцийн ангилалд хамрагдах 12 хэсэгшилд 26.69 кг алт (химийн цэврээр)-ны нөөцийг тогтоожээ. Ордын өргөний хил заагийг жишигийн захын агуулга бүхий малталт болон түүнтэй зэрэгцээ орших ядуу агуулгатай малталт хоорондын зайн хагасаар хязгаарласан байна.

хагасаар хязгаарласан байна.

**Хүчин чадал:** Уурхайн хүчин чадлыг “Эрдэнэ цагаач” ХХК-ийн техникийн даалгаврын дагуу жилд 29.0 мян.м3 элс угаах хүчин чадлаар ажиллахад ордын нийт батлагдсан нөөцийг 2 жилийн хугацаанд олборлох юм. Уурхайн ажиллах хүчийг “Эрдэнэ цагаач” ХХК-ийн инженер техникийн ажиллагсадын баг, орон нутгийн иргэдээс бүрдүүлнэ. Уурхай нь хүчин чадал бага, бүтэц зохион байгуулалтын хувьд нүсэр биш учир 24 хүн ажиллана.

Баяжуулах уурхайн хүчин чадал: Хүдэр баяжуулах бичилийн үйлдвэр нь 2 жил ажиллахаар төлөвлөж байгаа бөгөөд жилд 29.06 мян.м3, хоногт 190 м3 алтны хүдэр баяжуулна. Хүдэр баяжуулах үйлдвэр нь жилд 1 ээлжээр 153 хоног ажиллах бөгөөд ээлжинд уурхайн техникийн операторууд, жолооч, туслах ажилчид болон ИТА 8 цаг ажиллана.

**Уурхайн ажиллах горим:** Уг ордын уулын ажил нь улирлын чанартай явагдах бөгөөд 4-р сарын 15-наас 5-р сарын 01-нийг хүртэл бэлтгэл ажил, 5-р сарын 01-нээс 09-р сарын 30-ныг хүртэл хөрс хуулалт, элс олборлолт, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа явагдах буюу жилд нийтдээ 5 сар ажиллах юм.




Уурхайн олборлолтын үйл ажиллагаа нь хоногт 8 цагийн 1 ээлжээр ажиллах горимыг барина. Ингэснээр уг уурхайн нь жилдээ 153 хоног буюу 1102 цаг ажиллах юм. Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулах хугацаан дахь нийтээр амрах баярын өдрүүдийг 6 өдөр байна.

*Хүснэгт № 2 Уурхйн ажиллах шорим*

| д/д | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Хэмжээ | |
|---|---|---|---|---|
| | | | Хөрс хуулалт | Элс олборлолт |
| 1 | Ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 10 | 10 |
| 2 | Хоног дахь ээлжийн тоо | ээлж/хоног | 1 | 1 |
| 3 | Жилд ажиллах хоногийн тоо | хоног/жил | 150 | 150 |
| 4 | Жилд ажиллах сарын тоо | Сар/жил | 6 | 6 |
| 4 | Жилийн ажлын цагийн хэмжээ | цаг/жил | 1500 | 1500 |

Уурхайн нь хоногт 8 цагийн 1 ээлжээр ажиллах ба цаг ашиглалтын итгэлцүүр 0.9 байна. Хоногт 7.2 цаг ажиллана. Жилд 5-р сарын 01-ээс 09-р сарын 30 хүртэл нийт 183 хоног ажиллах бөгөөд 153 хоногт нь цэвэр олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулна.

Уурхайн горимд үндэслэн хоногийн хүчин чадал 189.93 $м^3$, цагийн хүчин чадал 26.38 $м^3$ байна.

**Уурхайн ашиглалтын систем:**

"Цахир жалга" алтны шороон орд нь дунджаар 2.4 м зузаантай хөрсний үеэр хучигдсан, дунджаар 0.6 м зузаан алт агуулсан элсний давхарга бүхий, уул- технологийн хувьд хялбар тогтоцтой тул ил уурхайн аргаар ашиглах нь зайлшгүй юм.

Ашиглалтын системийн хувьд бульдозер, экскаватор ба автосамосвалын хослол ашигласан тээвэртэй ба тээвэргүй ашиглалтын системээр ажиллана.

Шимт хөрсний давхаргыг бульдозероор түрж уурхайн хүрээний дагуу овоолго үүсгэнэ. Хөрс болон элсний давхаргыг экскаватор ашиглан олборлож автосамосвалаар тээвэрлэн хөрсний овоолгод хураах болон баяжуулах үйлдвэрийн хүлээн авах бункерт хүргэнэ.

***Хүснэгт № 3 Ашиглалтын технологийн схем***

| Ашиглалтын систем | Үндсэн ажил | Технологийн процесс |
|---|---|---|
| Авто тээвэртэй ашиглалтын систем | Хөрс хуулалт | Ухаж ачих |
| | | Тээвэрлэх (Гадаад ба Дотоод овоолго) |
| | Элс олборлох | Ухаж ачих |
| | | Тээвэрлэх (Угааж үйлдвэрлэх) |

**Ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүд:** Автотээвэр бүхий ил ашиглалтын системд доголын өндөр, орлын өргөн, мөргөцөг дэх ажлын талбайн өргөн, догол дахь фронтын урт гэсэн үндсэн хэмжээсүүд байна.

“Цахир жалга” алтны шороон ордыг автотээвэр бүхий ил уурхайн аргаар ашиглах ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээсүүдийг сонгон авсан экскаваторын техникийн үзүүлэлт болон ордын уул – геологийн нөхцлийг үндэслэн тогтоолоо. Ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэнд харуулав.

***Хүснэгт № 4 Ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүд***

| № | Үндсэн үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Утга |
|---|---|---|---|
| 1 | Элс олборлолтын ажлын доголын өндөр | м | 0.6 |
| 2 | Хөрс хуулалтын ажлын доголын өндөр<br>- Өнгөн хөрс хуулалтын үе<br>- Хөрс хуулалтын үе | м<br>м | 0.15<br>2.5 |
| 3 | Элс олборлолтын ажлын доголын хажуугийн өнцөг | град | 45-50 |
| 4 | Экскаваторын орлын өргөн | м | 10.00 |
| 5 | Экскаваторын ажлын фронтын урт | м | 30< |
| 6 | Автозамын налуу | % | 80.00 |
| 7 | Автозамын өргөн | м | 8.00 |

**Уурхайн хүрээ хязгаар, үндсэн хэмжээсүүд:** Ил уурхайн хүрээ хязгаарыг нөөцийн блокийн хилээр тогтоосон бөгөөд ил уурхайн ашиглалт явуулах гүний хэмжээг нөөцийн блокийн гүнээр буюу 3 метрийн гүнээр хязгаарлан тогтоосон байна.

***Хүснэгт № 5 Ил уурхайн хүрээ хязгаар***

| № | Үндсэн үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Хөрсний доголын өндөр | м | 2.5 |
| 2 | Олборлолтын доголын өндөр | м | 0.7 |
| 3 | Доголын налуугийн өнцөг | град | 45-50 |
| 4 | Ажлын талбайн өргөн | м | 10-15 |
| 5 | Уурхайн ёроолын хэсгийн хамгийн бага өргөн | м | 30.00 |
| 6 | Уурхайн хэмжээсүүд: (Газрын гадаргаар) | | |
| | Уурхайн нийт урт | м | 1740 |
| | Уурхайн дуундаж өргөн | м | 40 |

## Уурхайн тоног төхөөрөмж

***Хүснэгт № 6 Төслийн техник тоног төхөөрөмжийн хүчин чадлын тойм үзүүлэлтүүд***

| № | Техникийн нэр төрөл | Техникийн марк | Тоо хэмжээ, ш | Техникийн үзүүлэлт | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Түлш зарцуулалт /л/цаг/ | Нэгж ажлын багтаамж | Явах хамгийн их хурд, км/цаг |
| 1 | Скруббер | СБ-20 | 1 | | 20м$^3$/цаг | |
| 4 | Эксковатор | 320LC-7 | 1 | 100км/17-22л | 1.3 м$^3$ | 5.2 |
| 5 | Утгуурт ачигч | ZL-50 | 1 | 15 л/цаг | 3.0 м$^3$ | 13.4 |
| 6 | Бульдозер | SD-16 | 1 | 18. 2л/цаг | 5.0 м$^3$ | 10.0 |
| 7 | Автосамосвал | HOWO | 3 | 100км/32л | 25тн | 80.0 |

**Хөрс хуулалт:** Уурхайн ерөнхий төлөвлөлтийн дагуу ордын B'-01 блокоос олборлолтын ажил хийгдэнэ. Тухайн ордын байршил, тогтоц, геологи хайгуулын ажлын мэдээллээс харахад тус уурхайн хувьд тусгайлан хуулагдах шимт хөрс байхгүй байна.

Харин элс олборлолтын ажлын өмнө хучдас хөрсийг эхэлж хуулна.

Эхний жилийн нийт: Элс олборлолт -29.06 мян.м$^3$

Хөрс хуулалт 99.39 мян.м$^3$

Хөрс хуулалтын итгэлцүүр Кхөрс = 3.42 м$^3$ /м$^3$ байна.

**Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө**

Хөрс хуулалтыг ордын тогтцоос хамааран гадаад болон дотоод овоолгод тээвэрлэн түр овоолго үүсгэнэ. Төсөл хэрэгжих хугацаанд 198.89 мян.м$^3$ хөрс хуулж, 58.12 мян м$^3$ элс олборлоно. Элс олборлолтын ажил B-01 блокоос Hyudai-320LC-7 маркийн экскаватор, HOWO маркийн автосамосвалын хослолоор эхлүүлэх ба эхний жилд B-01-ээс B'-05 блокийн элсийг олборлоно. Түүнчлэн эфель ба галиас өдөр бүр 2-оос доошгүй удаа дээж авч шалган хаягдал гарч байгаа эсэхийг тогтмол хянаж байна. Үүний зэрэгцээгээр талбайн ус зайлуулах суваг татах, зам талбай байгуулах зэрэг ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэнэ. Элсийг бүрэн авах зорилгоор давхаргын дээр 0.15м, доор 0.15м, хажуу хананд 0.7м хоосон чулуулгийг ашиглалтын нөөцийн тооцоонд оруулсан болно. Элс угаах ажил 4-р сарын 15- ээс 10-р сарын 15 хүртэлх хугацаанд үргэлжилнэ. Хөрс хуулалтын ажил элс олборлолтын ажлаас 15 хоногоос багагүй хугацаагаар түрүүлж явах юм.

Цахир жалгын хөвийн ордоос 198.8 мян.м$^3$ хөрс хуулж, 58,12 мян.м$^3$ элс олборлон баяжуулахаар байгаа бөгөөд хөрс хуулалтын дундаж коэффициент 3.42 м$^3$/м$^3$ байна. Ашиглалтын хугацаанд уурхайгаас дунджаар 590.96 мг/м$^3$ агуулгатай. Дараах хүснэгтүүдэд уурхайн календарьчилсан төлөвлөгөөг үзүүллээ.

| № | Үзүүлэлтүүд | Ашиглалтын жилүүд | | Нийт |
|---|---|---|---|---|
| | | 1-р жил | 2-р жил | |
| 1 | Олборлолтонд өртөх талбай, мян.м$^2$ | 36.34 | 36.34 | **72.68** |
| 2 | Уулын цул, мян.м$^3$ | 128.45 | 128.45 | 256.89 |
| 3 | Хөрс хуулалт, мян.м$^3$ | 99.39 | 99.39 | 198.77 |
| 4 | Элс олборлолт, мян.м$^3$ | 29.06 | 29.06 | 58.12 |
| 5 | Хрөс хуулалтын коэффициент, м3/м3 | 3.42 | 3.42 | 3.42 |
| 6 | Элс боловсруулалт, мян.м$^3$ | 29.06 | 29.06 | 58.12 |
| 7 | Дундаж агуулга, мян.м$^3$ | 504.51 | 634.43 | 569.47 |
| 8 | Алт шлихээр, кг | 14.66 | 18.44 | 33.10 |
| 9 | Сорьц | 807 | 807 | - |
| 10 | Алт химi цэвэр, кг | 11.83 | 14.88 | 26.71 |
| 11 | Метал авалт, % | 85.1 | 85.1 | - |
| 12 | Бүтээгдэхүүн гаргалт (Алт - Шлихээр), кг | 12.48 | 15.69 | 28.16 |
| 13 | Бүтээгдэхүүн гаргалт (Алт – Химийн цэврээр), кг | 10.07 | 12.66 | 22.73 |

## Цахилгаан хангамж

Үйлдвэрлэлийн үндсэн цахилгаан хэрэглэгчид нь ил уурхайн хувьд алт угаах төхөөрөмж, контор, ажилчдын цайны газар, ажиллагсадын амрах байр, усны насос зэрэг болно. Мөн түүнээс гадна ашиглалтын туршид засварын газар, сэлбэг хэрэгсэлийн /материалын/ агуулах уурхайн тосгон зэрэг хэрэглэгчид 0.4кВ-ын цахилгаан эрчим хүчээр хангагдана.

*Хүснэгт № 7 Уурхайн цахилгаан хэрэглэгчид*

| № | Цахилгааны хэрэглэгчид | Тоо ширхэг | Суурилагдсан чадал кВт | | Хэрэгцээний итгэлцүүр | Тооцооны реактив чадал, кВтр($Q_1$) |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Нэгж | нийт | | |
| Уурхай, үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчид | | | | | | |
| 1 | **Гэрэлтүүлэг** | 4 | 4.5 | 18 | 0.3 | 5.4 |
| 2 | **Скрупер** | 1 | 100 | 100 | 0.8 | 80.0 |
| 3 | **Усны насос** | 1 | 6.5 | 6.5 | 0.8 | 5.2 |
| **Дүн** | | | | | | 90.6 |
| Тосгоны цахилгаан хэрэглэгчид | | | | | | |
| 1 | **Контор** | 1 | 2 | 2 | 0.86 | 1.72 |
| 2 | **Засварын газар** | 1 | 4 | 4 | 0.86 | 3.44 |
| 3 | **Ажилчдын байр** | 7 | 2 | 2 | 0.95 | 13.3 |
| 4 | **Харуулын байр** | 1 | 0.5 | 0.5 | 0.87 | 0.44 |
| 5 | **ШТСтанц** | 1 | 3.5 | 3.5 | 0.55 | 1.92 |
| 6 | **Халуун ус** | 1 | 5 | 5 | 0.70 | 3.5 |
| **Дүн** | | | | | | 24.32 |
| **Халуун ус** | | | | | | 114.92 |

Алт угаах Хятад улсад үйлдвэрлэсэн NIAN FENG маркийн төхөөрмж байна. Харин уурхайн тосгонд зөвхөн гэрэлтүүлэг, хоолны газар болон бусад бага хэмжээний хэрэглэгчидтэй учир 150кВт хүчин чадалтай дизель станц нь тэдгээрийг цахилгаанаар хангах боломжтой.




**Дулаан хангамж:** Уурхайн жилийн ажлын үргэлжлэх хугацаа 165 хоног тул хүмүүсийн оршин суух байрууд болон засварын зориулалттай вагончик зэргийг ердийн галлагаагаар дулаан хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ.

# 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

## Хөрсөн бүрхэвч

Төслийн талбай орчим нь хөрс газарзүйн мужлалаар Говийн их мужийн монголын өрнөд дэд бүсийн нууруудын хөндийн тойрогт хамаарна. Төслийн талбайн ойр орчим уулын хөрс тархана.

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутаг дэвсгэр, түүний дотор “Цахир жалга”-ын төслийн талбай байрлах бүс нутаг нь Монгол орны хөрс-географийн мужлалаар **Говийн бүс, хээрийн бүсийн шилжилтийн зааг** буюу дараах өвөрмөц онцлогтой мужид хамаардаг. Бөмбөгөр сумын нутаг дэвсгэрийн хөрс газарзүйн үндсэн үзүүлэлтүүдийг доорх байдлаар багцлан харуулж байна.

1. Хөрсний үндсэн хэв шинж

Бөмбөгөр сумын нутаг нь Хангайн уулархаг мужаас Говийн тал хөндий рүү шилжих зурваст оршдог тул хөрсний бүрхэвч нь босоо бүслүүр ба хэвтээ бүсийн шинжийг хоёуланг нь агуулдаг.

Төслийн талбай орчимд дараах хөрс голлон тархсан:

- **Цайвар хүрэн хөрс:** Хээрийн бүсийн урд захаар тархсан, ялзмаг багатай (1.0-2.0%), элсэрхэг, хөнгөн шаврандцар бүтэцтэй хөрс. Энэ хөрс нь механик нөлөөлөлд маш өртөмтгий, амархан эвдрэх шинжтэй.
- **Бор саарал ба Цөлөрхөг хээрийн бор хөрс:** Сумын урд болон нам доор хэсгээр говийн шинж чанартай бор хөрс давамгайлна. Ургамлын бүрхэвч сийрэг тул хөрсний үржил шимт үе нь маш нимгэн байдаг.
- **Голын татам, хөндийн нугын хөрс:** Жаргалант голын сав болон хуурай сайр, жалгын ёроолоор чийг мандал, усалгаанаас хамаарсан нугын ба хужир маргацтай хөрс ажиглагдана.

2. Хөрсний механик бүрэлдэхүүн ба шинж чанар

- **Элсэрхэг, хайргархаг бүтэц:** “Цахир жалга” нь өөрөө алтны **шороон орд** (alluvial deposit) тул угаасаа голын голдирол, жалгын дагуух элс, хайрга, сэвсгэр хурдас дээр тогтсон хөрстэй.
- **Үржил шим:** Ялзмагийн хэмжээ маш бага тул хөрсний өнгөн үеийг нөхөн сэргээлтэд зориулж хуулахдаа технологийн горимыг нарийн баримтлахгүй бол шимт чанараа амархан алдана.




*Зураг 11. Хөрсөн бүрхэвч*

## Хөрсний өнөөгийн төлөв байдал

Нийт 6 цэгээс хөрсний өнгөн үеийн дээж аван шинж чанар, бохирдлын түвшнийг тодорхойллоо. Судалгаанд хамрагдсан дээжүүд нь ялзмагийн агууламж бага, бага шүлтлэгээс хүчтэй шүлтлэг урвалын орчинтой, давсжилтгүй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

Хөрсөнд агуулагдах хүнд металлын хувьд хүнцэл, зэс, ванадийн агууламж элсэнцэр хөрсөнд хүлцэх хэмжээг зарим цэгт давсан ч стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээг даваагүй байна.

## Ургамлан нөмрөг

**Ургамалжлын бичиглэл:** Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутагт орших "Цахир жалга" алтны шороон ордын төслийн талбайд 3 бичиглэл хийхэд үндсэн бүлгэмдэл нь:

**У-ууландаа** Ерхөг -хялгана -чулуусаг алаг өвс-агь шавагт (53 /У-V-1-5), Хялгана-ерхөг-чулуусаг алаг өвст (52/У-V-1-5),

**Н-Нам хотосын** уулын гаралтай Дэрст (241/Н-V-1-1) бүлгэмдэлтэй байна.

Тус талбай нь газрын гадаргын төрх байдлаараа уул толгодын чулуурхаг хээр, уулын гаралтай нам хотосын дэрст ургамалжлын төрхтэй, ургамлан нөмрөгийн 100 $м^2$ талбайд 15-20 зүйл, 1$м^2$ талбайд 4-8 зүйл бүртгэж, ургамалжлын хувьд ургамлын тусгагын бүрхэц хагдаа оруулаад уулсын чулуурхаг хээрээр 42.2-46.0%, нам хотосоор 55.2%, га –ийн ургац уул толгодоор 1.066-1.64 цн байхад уулын гаралтай дэрст нам хотосоор 2.102 цн –ийн ургац бүрэлдсэн байна.

*Хүснэгт № 8 Ургамалжлын бичиглэл*

| № | Бэлчээрийн төрөл | Бэлчээрийн ургамалжлын шалгуур үзүүлэлт | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зүйлийн тоо (100м2 талбайд) | Зүйлийн тоо (1м2 талбайд) | Ургамлын бүрхэц, % | Олшрогч ургамлын бүрхэц, % | Халцгай газар, % | Хад, хайрга, чулуу, % | Хагд, % | Ургац, ц/га |
| 1 | Ерхөг -хялгана -чулуусаг алаг өвс-агь шавагт (53 /У-V-1-5) | 19 | 5 -6 | 42.2 | 5.4 | 35.0 | 22.8 | 42.2 | 1.066 |
| 2 | Дэрст (241/Н-V-1-1) | 20 | 4 -8 | 55.2 | 11.6 | 38.8 | 6.0 | 55.2 | 2.102 |
| 3 | Хялгана-ерхөг-чулуусаг алаг өвст (52/У-V-1-5) | 15 | 4-6 | 46.0 | 2.8 | 24.4 | 19.6 | 46.0 | 1.64 |

*Зураг № 1 Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутагт орших "Цахир жалга" алтны шороон ордын төслийн ургамлан бүрхэвчийн ургамалжлын төлөв байдлын зураг*

**Уур амьсгал**

Төслийн талбай орчимд зуны улиралд эх газрын дулаан хуурай агаар зонхилдог. Иймээс орох хур тунадас ихэнхдээ аадар шинжтэй байдаг. Намар хур тунадас багасаж, цочир хүйтрэлт 8 дугаар сарын сүүлч, 9 дүгээр сарын эхээр ажиглагдсан 10 дугаар сарын сүүлч, 11 дүгээр сарын эхээр өвлийн нөхцөлдөө шилжин ордог.

Баянхонгор аймгийн нутаг нь хангай, тал хээр, говь хосолсон уудам дэлгэр нутагтай тул дулаан хүйтний хэлбэлзэл ихтэй сүүлийн жилүүдийн байдлаар нийт нутгаар жилийн дундаж агаарын температур дунджаар 2.00С дулаарсан хэдий ч улирлаар нь авч үзвэл: Ихэнх нутгаар өвлийн улиралд 1.4-өөс 2.5 градус, хавар зуны улиралд 0.2-оос 1.0 градусаар дулаарсан, нутгийн өмнөд хэсгээр өвлийн улиралд -0.2-оос -2.0 хүйтэрсэн хэдий ч зуны улиралд 2.0 градусаар дулаарч ажиглагдаж байна.

Баянхонгор аймагт агаарын дундаж температур нь жилд -0.7° бөгөөд 1 сард -18.4° хүйтэн, 7 сард 15° дулаан болдог. Жилд дунджаар 216.3 мм тунадас унана. Агаарын даралтын дундаж нь 1 сард 812 мм, 7 сард 808.5 мм байна. Салхины хурд жилийн дунджаар 3.1 м/с бөгөөд хамгийн их салхитай, 5 сард 3.9 м/с хүрнэ.

**Гадаргын ус**

Төслийн талбайн баруун, баруун хойд хэсгээр Төв Азийн гадагшаа урсгалгүй ай савд хамаарах Байдраг, Өлзийт, Уртын зэрэг байнгын урсгал устай томоохон голуудтайгаас гадна талбайд байнгын урсгал устай жижиг гол горхи, булаг шандууд үл тохиолдоно. Гол, горхи, булаг шандын үндсэн тэжээгдтэл нь гүний ба хур тунадасны усаар явагдана. Голын усны урсац, зарцуулалт нь тухайн жилийн хур тунадасны хэмжээнээс шууд хамааралтай. Хур бороо элбэг жил байнгын урсгал устай гол горхинуудаас гадна зарим нэг хуурай сайрууд устай байдаг бол гантай жилд томоохон голуудаас бусад нь ширгэж хуурай сайр болдог байна. Гадаргын усны дийлэнх нь 30-100 мг/л эрдэсжилттэй учир зөөлөн усанд тооцогдоно.

# 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

**Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:** Байгаль орчны шинжилгээ, магадлан жагсаах аргын үнэлгээний үр дүн зэргээс үзэхэд агаар орчин сөрөг нөлөөлөл үзүүлэх эх үүсвэр, түүний төрөл, тайлбар зэргийг дараах хүснэгтэнд нэгтгэн оруулав.

*Хүснэгт № 9 Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл*

| № | Агаарын бохирдлын эх үүсвэр | Төрөл |
|---|---|---|
| 1 | Тэсэлгээнээс үүсэх тоосонцор | Эзлэхүүн |
| 2 | Тэсэлгээ /үр дүнд үүсэх ухаш/ | Эзлэхүүн |
| 3 | Ухаж ачих үед үүсэх тоосжилт | Талбайн |
| 4 | Тээвэрлэлтээс үүсэх тоосжилт | Шугаман |
| 5 | Тээвэрлэлтээс үүсэх хийн ялгаралт | Шугаман |
| 6 | Овоолгоос дэгдэх тоос тоосонцор | Эзлэхүүн |
| 7 | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт | Шугаман |
| 8 | Тэсэлгээнээс үүсэх дуу чимээ | Цэгэн |
| 9 | Ухаж ачих үеийн тоног төхөөрөмжийн дуу чимээ | Цэгэн |
| 10 | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс гарах дуу чимээ | Цэгэн |
| 11 | Ахуйн шингэн хаягдал | Цэгэн |
| 12 | Ахуйн хатуу хаягдал | Цэгэн |
| 13 | Шатах тослох материалын агуулахаас бензин дизель түлш алдах | Цэгэн |

Эдгээр эх үүсвэр тус бүрээр үүсэх хийн ялгаралтыг ОХУ-ын Эрхүүгийн эрдэмтдийн аргазүй, АНУ-ын Байгаль орчны агентлагаас гаргасан аргазүй зэргийг ашиглав.

**Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:** Уурхайн олборлолтын болон бусад төрлийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийн эх үүсвэр нь:

- Олборлолтын үйл ажиллагаанаас
- Хөрсний овоолгод хөрс дарагдах
- Дотоод тээвэрлэлтийн зам нь шугаман элэгдлийн эх үүсвэр болно. Мөн энэхүү элэгдэл нь агаар дахь тоосонцрын эх үүсвэр болж, тоосонцор нь буцаад хөрсөн бүрхэвчийн шинж чанарт сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

**Газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөлөл:**

- **Геологийн тогтоц, үелэлийн эвдрэл:** Цахир жалгын хөвийн ордоос 198.8 мян.$м^3$ хөрс хуулж, 58.12 мян.$м^3$ элс олборлох явцад тухайн газрын геологийн тогтоц, хурдас дундын үе давхаргууд бүрэн задарч, анхны бүтцээ алдана.
- **Гүний усны горимын өөрчлөлт:** Шороон ордын элс агуулсан үе давхаргыг ухаж, угааж баяжуулах явцад тухайн орчны хөрсний чийгшил, уст үе давхаргын байршил өөрчлөгдөнө. Ил уурхайн ухаш руу шүүрэх гүний ус нь уурхайн шүүрүүлэх ажиллагаанаас шалтгаалж доошлох, эсвэл гидрогеологийн тэнцвэрт байдал алдагдах эрсдэлтэй.
- **Хөрсний нягтрал ба даацын өөрчлөлт:** Хүнд даацын машин механизм, уурхайн техникүүд талбай дээр ажилласнаар тээврийн замууд болон туслах талбайн хөрс хэт нягтарч, дахин ургамал ургах, ус нэвтрүүлэх чадваргүй болж хатуурах (деградацид орох) сөрөг нөлөө үзүүлнэ.

**Гадаргын болон гүний усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл:**

**Төрх байдал, рельефийн бүрэн өөрчлөлт:** Нийт **12.3 га** талбайн ургамлын бүрхэвч, хөрсний үржил шимт үеийг хуулж авснаар тухайн орчны байгалийн унаган төрх бүрэн алдагдана. Ил уурхайн ухаш (карьер), овоолгууд үүсэж, газрын гадаргуугийн рельеф (хотгор, гүдгэр) өөрчлөгдөнө.

- **Хөрсний элэгдэл, эвдрэл (Эрози):** Одоогийн байдлаар 5.1 га талбай эвдрээд байгаа бөгөөд нэмж 7.2 га талбайг сийрэгжүүлэн хөрс хуулалт хийх үед салхины болон усны эрозид өртөх нөхцөл бүрдэнэ. Ургамлын бүрхэвчгүй болсон хөрс амархан хийсэж, угаагдана.
- **Тоосжилт үүсэх:** Хөрс хуулалт, тээвэрлэлт, элс олборлолтын явцад техникийн хөдөлгөөнөөр газрын гадаргуу суларч, орчин тойронд их хэмжээний тоосжилт үүсэх үндсэн шалтгаан болно.

- ✓ Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих, улмаар хөрсний бага гүний усыг бохирдуулах
- ✓ Улын ажлын болон ахуйн бохир ус хадгалах савыг соруулах үед асгарч газрын хэвлий болон хөрсийг бохирдуулахаас үүдэн хөрсний усыг бохирдуулах
- ✓ Улын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч халихаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус болон бага гүний усыг бохирдуулах
- ✓ Техник, тоног төхөөрөмжийн шатах тослох материал алдагдаж хөрсийг бохирдуулахаас үүдэн хөрсний усыг бохирдуулах
- ✓ Уурхайн байгууламж, хоосон овоолго, хаягдлын сан, техник хэрэгслийн байршуулалт зэргээр газрын гадаргыг өөрчилж улмаар байгалийн хур тунадас унаж урсац бүрдэх, хөрсний чийг, газрын доорх усыг сэлбэх нөхцөлийг доройтуулах магадлалтай.

**Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим:** Уг төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, судалгаа хийсэн мэргэжлийн судлаачдын дүгнэлтүүдийг үндэслэн тогтоов. Байгаль орчны төлөв байдал гарч болзошгүй нөлөөлөл, болзошгүй ослын үнэлгээг магадлан жагсаах аргаар тодорхойлов.

Магадлан жагсаах /checklist/ аргаар тооцсон нөлөөллийн үнэлгээ: Үнэлгээ хийгдэж буй төслийн үйл ажиллагаа байгаль орчны төлөв байдал, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг тодруулахын тулд магадлан жагсаах (checklist) аргыг ашиглав. Энэ арга нь нөлөөллийг байна (x), байхгүй (хоосон) гэсэн хэлбэрээр тодорхойлж шууд, шууд бус шинжтэй, удаан, богино хугацаагаар буцалтгүй болон буцаж нөлөөлөх, хүчтэй, дунд болон бага зэрэг эрчимтэй байх зэрэг үзүүлэлтүүдээр авч үзсэн болно.

*Хүснэгт 7. Болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим*

| № | Байгаль орчны үзүүлэлт | Нөлөөлөл | | | Хугацаа | | Давтамж | | Эрчим | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Шууд | Шууд бус | Өөрөө | Богино хугацааны | Удаан хугацааны | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй нөлөөлөх | Бага зэрэг | Дунд зэрэг | Хүчтэй |
| Байгалийн экосистемийн өөрчлөлт | | | | | | | | | | | |
| 1 | Газрын доорх урсцын өөрчлөлт | | | | | | | | | | |
| 2 | Гадаргын усны чанарын өөрчлөлт | | х | | | х | х | | | х | |
| 3 | Ургамлан бүлгэмдлийн бүтцийн өөрчлөлт | х | | | | х | | х | | | х |
| 4 | Хөрсний элэгдэл, эвдрэл | х | | | | х | | х | | | х |
| 5 | Геологийн тогтцын өөрчлөлт | х | | | | х | | х | | х | |
| 6 | Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт | х | | | | х | | х | | х | |
| 7 | Уур амьсгалын өөрчлөлт | | х | | | х | | х | х | | |
| Байгалийн нөөцийн ашиглалт | | | | | | | | | | | |
| 8 | Газрын доорх нөөц баялаг | х | | | | х | | х | | х | |
| 9 | Бэлчээрийн байдал | х | | | | х | | х | | х | |
| 10 | Эрдэс түүхий эдийн нөөц | х | | | | х | | х | | х | |
| Байгаль орчны чанарын өөрчлөлт | | | | | | | | | | | |
| 11 | Агаарын бохирдол | х | | | х | | х | | | х | |
| 12 | Ундны усны нөөц хомсдох | | х | | | х | | х | х | | |
| 13 | Хөрсний бохирдол | | х | | | х | х | | | х | |
| 14 | Дуу чимээ, шуугианы нөлөөлөл | х | | | х | | | х | | х | |
| Нийгэмд үзүүлэх нөлөөлөл | | | | | | | | | | | |
| 15 | Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх | х | | | | х | | х | х | | |
| 16 | Хүн амын орлого өөрчлөгдөн нэмэгдэх | | х | | | х | | х | х | | |
| 17 | Хүн амын тоо өөрчлөгдөх | | х | | | х | | х | х | | |
| Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентлогийн олдвор | | | | | | | | | | | |
| 18 | Байгалийн өнгө төрх өөрчлөгдөх | х | | | | х | | х | | | х |
| 19 | Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх | х | | | | х | | х | | х | |
| 20 | Тусгай хамгаалалттай ба цогцолборт газарт нөлөөлөх | | | | | | | | | | |
| 21 | Түүх сёлын дурсгалт зүйлд нөлөөлөх | | | | | | | | | | |
| 22 | Археологи, палентлогийн олдворт нөлөөлөх | | | | | | | | | | |
| Эдийн засаг, байгаль орчин | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | Орон нутгийн орлого нэмэгдэх | | x | | | x | | x | | x | |
| 24 | Ажлын байр нэмэгдэх | x | | | | x | | x | | x | |
| 25 | Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох | | x | | x | | | x | x | | |
| Бусад нөлөөлөл | | | | | | | | | | | |
| 26 | Шороон зам, уурхайн машин механизмын хөдөлгөөн, тээвэрлэлтээс хөрс эвдрэх | x | | | | x | x | | | | x |
| 27 | Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба усыг бохирдуулах | x | | | | x | x | | | x | |
| 28 | Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих | x | | | x | | x | | | x | |
| 29 | Хүчтэй салхи, уруйн үер | x | | | x | | x | | | x | |
| Дүн | | 18 | 8 | | 5 | 20 | 7 | 18 | 5 | 15 | 6 |

Дээрх хүснэгтээс харахад тус төслийн үйл ажиллагааны явцаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой нэг нь нөгөөдөө шууд буюу дам байдлаар нөлөөлөх нь харагдаж байна.



# 4. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан 2019 оны А/168 тоот “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг үндэслэл болголоо.

Байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Байгаль орчны бохирдлоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Уурхайн барилга байгууламж барих, олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэх

- Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд 18,750төг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах аргазүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

*Хүснэгт 8. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа*

| № | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө | Нийт зардал /мян.төг/ |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө | 6,500 |
| 2 | Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө | 600 |
| 3 | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө | 1,000 |
| 4 | Тэрбум мод | 2,000 |
| 5 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | -- |
| 6 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 700 |
| 7 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 2,100 |
| 8 | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө | 2,000 |
| 9 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 3,400 |
| 10 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 200 |
| 11 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө | 250 |
| **2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал** | | **18,750** |

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Эрдэнэ цагаач” ХХК -ийн Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутагт орших “Цахир жалга” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөлийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг нэгтгэж доорх хүснэгтэд тусгалаа.

*Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Жилийн зардал (мян.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|
| **АГААР ОРЧИН** | | | | | | |
| 1 | Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох | Суурьшлын бүсэд ойр байрлах уурхайн зам талбайд тоосжилтын түвшнээс хамааран усалгааны давтамжийг нэмэгдүүлж, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах. | Хуурайшилт ихтэй үеүдэд /дотоод тээвэрлэлтийн зам дагуу/ | 500 | Жил бүрийн 6-9р саруудад (сард 2-4удаа), 10-11р саруудад (сард 1-2удаа) | MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага |
| 2 | | Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яаралтай авах, саармагжуулах хэрэгслийг талбайд бэлэн байлгах | Уурхайн ашиглалтын талбайд байнгын бэлэн байлгах | 150 | Үйл ажиллагааны турш | Агаарын тухай хууль,<br>MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага<br><br>Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998<br><br>MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. |
| 3 | | Тоос дарах | Үйл ажиллагааны турш | 300 | Жилд 1 удаа | |

**БАЯНХОНГОР АЙМГИЙН БӨМБӨГӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ "ЦАХИР ЖАЛГА" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Жилийн зардал (мян.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | | Машин механизмын засвар үйлчилгээг зориулалтын талбайд хийж гүйцэтгэх | Төсөлд ашиглагдаж буй техник хэрэгслүүд | 100 | 2026 онд | Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм, түвшний хэмжээ |
| 5 | | Уурхайгаас дотоод гадаад тээврийн гол замын сүлжээ, маршрутыг тогтоох | Гадаад, дотоод тээврийн зам | 100 | Үйл ажиллагааны турш | |
| 6 | | Ашиглагдаж буй машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, агаар бохирдуулсны төлбөрийг төлөх, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх | Төсөлд ашиглагдаж буй техник хэрэгслүүд | 100 | Үйл ажиллагааны туршид | |
| **Дүн /төгрөг/** | | | | **1.250** | | |
| **ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ** | | | | | | |
| 8 | Газрын гадарга эвдэрч, Хөрсний үржил шим алдагдах, бохирдох, эвдрэх, доройтох | Хөрс шатах тослох материалаар бохирдохоос сэргийлж дотоод тээврийн талбайг сайжруулсан шороон зам болгох, тэмдэгжүүлэх. | Уурхайн засварын талбай | 1,000 | 2026оны 8-9сар | Хөрс хамгаалах Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль<br>Газрын тухай хуулийн 50.1.1<br>MNS5914:2008, "Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт" MNS5918:2008, "Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага" |
| 9 | | Хог хаягдлаар дамжин хөрсний бохирдол үүсгэхгүйн тулд хог хаягдлын эцсийн цэгт хүргэх | Ахуйн хог хаягдлын цэг | Хог хаягдлын МТ-д тусгасан | Тогтмол | |

**БАЯНХОНГОР АЙМГИЙН БӨМБӨГӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАХИР ЖАЛГА” НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар,хэмжээ | Жилийн зардал (мян.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|
| 10 | | Асгаралтын иж бүрдэлийг төслийн талбайд бэлэн байлгах | Үйл ажиллагааны турш дотоод хяналт хийх | 100 | Үйл ажиллагааны туршид | MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага” “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал MNS5916:2008 “Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт , хадгалалт” |
| 11 | | Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах | Уурхайн дотоод, гадаад тээврийн зам | ОЭМТ-д тусгасан | Үйл ажиллагааны туршид | |
| 12 | | Үржил шимт хөрсний овоолго болон хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй хураах, салхи болон усны элэгдлээс хамгаалах арга хэмжээ авч, нөхөн сэргээлтийн үед дахин ашиглах. | Үйл ажиллагааны турш | 200 | Үйл ажиллагааны туршид | |
| 13 | | Хөрсний үржил шим алдагдахаас сэргийлж шимт хөрсний овоолгыг ургамалжуулах, тогтмол усалж арчлах | Үйл ажиллагааны турш | 200 | 2026оны 8-9сард | |
| 14 | Ургамлан нөмрөг талхлагдахаас сэргийлэх | Ургамлан нөмрөгийн доройтлыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор зүлэгжүүлэлт болон олон наст цэцэг, ургамал тарина. | Ажилчдын байрны гадна талбайд | 100 | 2026оны 9сард | |
| **Дүн /төгрөг/** | | | | **1,600** | | |
| **ГАЗРЫН ДООРХ УС** | | | | | | |
| 15 | Унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар | Унд ахуй хангаж буй гүний худагт хяналт шинжилгээг явуулах | Уурхайн усан хангамж хангаж буй гүний худаг | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан | Жилд 1 удаа | Усны тухай хууль: Зүйл 24-1.1, 1.2; Зүйл 30; Зүйл 31-1, 2, 3, 4, 5, 6, 8; Зүйл 33-1, 2, 3; Зүйл 34-1, 2; Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий |

**БАЯНХОНГОР АЙМГИЙН БӨМБӨГӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАХИР ЖАЛГА” НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Жилийн зардал (мян.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|
| 16 | Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн зэрэг бодис алдагдах, хур тунадас болон үерийн усаар угаагдан усан орчинг бохирдуулах | Ус ашиглуулах зөвшөөрөл болон Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулах | Усны хэрэглээгээр | 200 | 2026 оны | шаардлага” MNS4596:1998. БОНБНҮ, Компанийн дотоод журам, |
| 17 | | Усны бүх эх үүсвэрийг тоолууржуулах (ус шавхах насос, худаг г.м) | Үйл ажиллагааны турш | 300 | 2026оны 9-10сар | |
| 18 | | | | 2900,0 | 2026оны 9-10сар | |
| **Дүн /төгрөг/** | | | | **3,400** | | |
| **АМЬТНЫ АЙМАГ** | | | | | | |
| 19 | Мал, амьтан ил уурхайн ухаш, далан шуудууруу унаж эрсдэх | Ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа хэсгийг бүхэлд нь хашаажуулан мал амьтан орохоос сэргийлэх | Олборлолт явуулж байгаа талбай | 250 | 2026оны 8-9сар | Амьтны тухай хууль<br>Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм:<br>7.3.4 Шороон ордын элсийг баяжуулж ашигт эрдсийг ялгах үеийн аюулгүй ажиллагааны шаардлага |
| **ДУУ ЧИМЭЭ** | | | | | | |
| 20 | Нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах | Олборлолтын ажлыг оройн 22:00 цагаас хойш гүйцэтгэхгүй байх | Үйл ажиллагааны турш | ҮАЗ-д тусгасан | Үйл ажиллагааны турш | MNS ISO 556:5003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ |

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Жилийн зардал (төгрөг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|
| **Дүн** | | | | **-** | | |
| **НИЙТ /ТӨГРӨГ/** | | | | **6,500,0** | | |

## 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Цагаан давааны зүүн хойд хэсгийн барилгын чулууны ордын нөхөн сэргээлтийг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008” стандартад нийцүүлэн БОНХАЖ-ын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэх ба нөхөн сэргээлтэд шаардагдах зардлыг Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамны сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайдын хамтарсан 2010 оны 05 сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу тооцоолно.

Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хууль, мөн БОАЖ-ын сайдын баталсан журмуудад зааснаар: Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн зардлын 50%-ийг байгаль орчныг нөхөн сэргээх баталгаа (бондыг) төрийн сан дахь тусгай дансанд байршуулна.

Төслийн үйл ажиллагаа өмнөх жилд явагдаагүй бөгөөд 1 дэх жил болох 2026 онд уул техникийн нөхцөлөөр техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.

**БАЯНХОНГОР АЙМГИЙН БӨМБӨГӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ "ЦАХИР ЖАЛГА" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал /мян.төг/ | Нийт зардал /мян.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрхзүйн баримт бичиг,стандарт аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Шимт хөрсийг хуулах тээвэрлэх, овоолгыг хадгалах, хамгаалах.<br>Ухаш болон овоолгын гадаргууг хэвгийжүүлэн тэгшлэх | Үйл ажиллагааны турш | - | 600 | 600 | 2026 оны | MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах, хадгалах техникийн шаардлага<br>MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага<br>MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага<br>MNS 4915:2000 Ашигт малтмал эрж хайх явцад эдвэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага |
| **Нийт дүн, төг** | | | | **600,0** | | | |

## 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ*

| № | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал /мян.төг/ | Нийт зардал /мян.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрхзүйн баримт бичиг,стандарт аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Аймгийн Байгаль орчны газраас санал авч дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх | булаг шандын эхийг хашиж хамгаалах, сэргээн засварлах | - | 1,000 | 1,000 | 2026оны 9-10сар | MNS 5914:5015, MNS 4597:5013 |
| **Нийт дүн,төг** | | | | **1,000** | | | |

## 8. ТЭРБУМ МОД

| № | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал /мян.төг/ | Нийт зардал /мян.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрхзүйн баримт бичиг,стандарт аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Аймгийн Байгаль орчны газраас өгсөн саналын дагуу Төслийн талбайд тарих | Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих | 300 | - | 2,000 | 2026 онд | MNS 5914:2015, MNS 4597:2013 |
| **Нийт дүн,төг** | | | | **2,000** | | | |

## 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн талбайд одоогоор түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй байна. Шаардлагатай тохиолдолд 700,000 төгрөг төсөвлөв. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай.

# БҮЛЭГ 10 .ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 11. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө*

| Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж |
|---|---|---|---|
| Цаг агаарын үзэгдэл ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гаргах | Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбар байршуулах | 300 | Үйл ажиллагааны турш |
| Шороон шуурга | Уурхайд онцгой байдлын журам боловсруулан мөрдөж ажиллах | 300 | Жилд 1 удаа |
| Үер | Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл, холбооны хэрэгсэлтэй болох | 250 | Жил бүр |
| Гэнэтийн осол эрсдэл | Осол эрсдэлээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах | 250 | Жил бүр уурхай эхлэх үед |
| | Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмалыг байрлуулах | 250 | Өдөр бүр ээлжинд гарахын өмнө |
| | Гэнэтийн гал түймэр, гамшиг осолтой тэмцэх аргачилсан заавар зөвлөгөөг боловсруулж өөрийн ОБХТ (ослын байдлын хязгаарлах төлөвлөгөө)-д тусгах, өөрөөр хэлбэл авах ёстой арга хэмжээний дэс дарааллыг тодорхой тусгах | 250 | Жил бүрийн I улиралд байрлуулан сар бүр шалгаж байх |
| | Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах | Үйл ажиллагааны зардалд тусгасан | Жил бүр |
| Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах | - Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтад хамруулах<br>- Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах<br>- Уурхайн талбай дотод таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулах | 400 | Жил бүр, жилд 1 удаа |
| **Нийт зардал /төгрөг/** | | **2100,0** | |

## БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө*

| Болзошгүй сөрөг нөлөөлөл | Нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Нийт зардал мян.₮ | Хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|
| Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйг ээс орчин бохирдох. Аюултай хог хаягдал хөрсөнд нэвчин орохоос сэргийлэх | Энгийн хог хаягдлын ангилан ялгадаг хогийн савыг тавих | Уурхайн хотхон | 400 | Төслийн эхэн үед | Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд<br><br>Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл<br><br>Засгийн газрын 116-р тогтоол |
| | Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх | Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах | 400 | Төсөл хэрэгжих хугацаанд | |
| | Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх | Ажилчдын байр | 400 | Төсөл хэрэгжих хугацаанд | |
| | Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй тохижуулах | Зориулалтын хог хаягдлын цэг | | Төсөл хэрэгжих хугацаанд | |
| | Ашигласан тос, масло хийх зориулалтын сав,түр хадгалах цэгтэй байх | Уурхайн ашиглалтын талбайд | 400 | Төсөл хэрэгжих хугацаанд | |
| | Аюултай хог хаягдлын гэрээг байгуулан мэргэжлийн байгууллагад нийлүүлэх | Уурхайн шингэн хаягдлын хүрээнд | 400 | Төсөл хэрэгжих хугацаанд | |
| **Нийт зардал** | | | **2000,0** | | |

# БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

*Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл | Хяналт шинжилгээ хийх байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал (мян.төг) | Нийт зардал (мян.төг) | Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1. Хөрсний бохирдол** | | | | | | | | |
| 1 | Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд | Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх | Кемпийн урд<br>Кемпийн хогийн цэгийн хажууд<br>Засварын цех<br>Ухашын хажууд<br>Хөрсний овоолгын хажууд<br>Постын хажууд<br>Хяналтын цэг – 1 цэгт | 2026 он | Улирал тутамд нэг удаа | 0,75 | 450 | Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. (2008). Монгол улсын стандарт - MNS 5850:2008. Улаанбаатар.<br>Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох арга. (1991). Монгол улсын стандарт - MNS 3310:1991. Улаанбаатар.<br>Хөрсний чанар. Хөрсөнд эрүүл зүйн нян судлалын шинжилгээ хийх арга. (2012) MNS 6341:2012. Улаанбаатар.<br>14Хөрс. Гэдэсний бүлгийн нян ,гэдэсний бүлгийн халуун даадаг нян болон байж болох E.Coli-г илрүүлэх арга. (2004) MNS 5367:2004. УлаанбаатарMNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| 2 | Хүнд металлын агууламж | Түлш, тосолгооны материал болон хог хаягдлаар хөрс бохирдох | Хяналтын цэг – 1 цэгт | 2026 он | Улирал тутамд нэг удаа | 140 | 550 | |

**БАЯНХОНГОР АЙМГИЙН БӨМБӨГӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАХИР ЖАЛГА” НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

| УСАН ОРЧИН | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Ерөнхий хими физикийн шинжилгээ<br>Урвалын орчин (pH)<br>Хүнд металлын шинжилгээ<br>(Унд ахуйн худгийн усанд микробиологийн шинжилгээг хийлгэх) | Газрын доорх усан орчин хүнд металл бохирдох | Худаг 1 | 2026 он | Улиралд 1 удаа – 1 цэгт | 210 | 600 | MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж<br>MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага<br>MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж<br>MNS 13.060.50 Усны чанарын стандарт<br>MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт |

**БАЯНХОНГОР АЙМГИЙН БӨМБӨГӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАХИР ЖАЛГА” НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Агаарын чанар** | | | | | | | | |
| | Ерөнхий химифизикийн шинжилгээ<br>Урвалын орчин (pH)<br>Хүнд металлын шинжилгээ<br>(Унд ахуйн худгийн усанд микробиологийн шинжилгээг хийлгэх) | Дотоод хяналт шинжилгээний цэгүүдэд | Худаг 1 | 2026 он | Жилд 1 удаа | 55 | 500 | Байгаль орчны мэргэжилтэн,<br>ШУА Ботаникийн хүрээлэнтэй хамтарч ажиллах |
| **Амьтны мониторинг** | | | | | | | | |
| | Шувууны үүр хийх | - | Төслийн талбай болон түүний ойролцоох талбайд | | Жилд 1 удаа: зун - намар | | 200 | |
| **Нийт дүн** | | | | | **3400,0** | | | |

# БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 14. БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө*

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Зардал мян.төг | Хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах | Ил уурхайн хүрээнд | Дотоод зохион байгуулалтаар | 2026 он |
| 2 | Байгаль орчныг хамгаалах, осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар жилд 1 удаа сургалт, зохион байгуулах | Ил уурхайн хүрээнд | Осол эрсдэлийн менежментийн зардалд тусгасан | 2026 он |
| 3 | Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ-д хүргэн өгч байх | Аж ахуй нэгжийн хэмжээнд | Дотоод зохион байгуулалтаар | Жил бүрийн 12 сард |
| 4 | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө | Ил уурхайн хүрээнд | Дотоод төлөвлөлтөөр | 2026 он |
| 5 | Газрын төлөв, байдал чанарын хянан баталгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх | Ил уурхайн хүрээнд | Дотоод төлөвлөлтөөр | 2026 он |
| 6 | ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах | Ил уурхайн хүрээнд | Дотоод төлөвлөлтөөр | Улирал бүр |
| 7 | Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах | Ил уурхайн хүрээнд | Дотоод зохион байгуулалтаар | Жил бүр |
| 8 | Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал | Уурхайн кемпийн хүрээнд | 200 | 2026 он |
| **Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал** | | | **200,0** | |

# БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн дүүргийн иргэдийн хуралд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийж байх шаардлагатай болно.

*Хүснэгт 15. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах төлөвлөгөө*

| **БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд** | **Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр** | **Мэдээний агуулга** | **Хугацааны тов** | **Тайлагнах зардал, мян.төг** | **Зохион байгуулах албан тушаалтан** | **Зохион байгуулах газар** |
|---|---|---|---|---|---|---|
| БОМТ тайлагнах<br><br>Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх | БОМТ-ний<br><br>Биелэлтийн тайлан | Тайланг хүлээн авсан<br><br>актыг хүргүүлэх | 2026.11.01-ний<br><br>дотор | 250 | “Эрдэнэ цагаач” ХХК | |
| **Нийт** | **250,0** | | | | | |